

МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН 2020 ОНЫ ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Хурлын нэр:	МЦХ ХК-ийн 2020 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал		
Огноо:	2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр 11:00-14:00	Уулзалтын газар:	Компанийн хурлын заал, бусад гурван уулзалтын өрөө
Хурлын дарга:	Чулуунбатын Пүрэвсүрэн, МЦХ ХК-ийн Стратеги төлөвлөлтийн газрын дарга		
Тооллогын комисс:	Тооллогын комиссын дарга Д.Ганцэцэг, Дотоод аудит, шинжилгээ үнэлгээний албаны мэргэжилтэн Гишүүд: Б.Ариунгэрэл, Удирдлага хүний нөөцийн газрын ахлах мэргэжилтэн О.Содбаяр, Хүний нөөцийн албаны хуулийн мэргэжилтэн		
Хурал зохион байгуулах комисс:	Зохион байгуулах комиссын дарга Д.Болдбаатар, МЦХ ХК-ийн Удирдлага, хүний нөөцийн газрын дарга Гишүүд: Х.Цэцэгмаа, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ж.Азбаяр, Удирдлага, хүний нөөцийн газрын хуулийн ахлах мэргэжилтэн		
Оролцсон хувьцаа эзэмшигчид	1. М.Шигшээ	Хувьцааны тоо 4 ширхэг	Компанийн нийт гаргасан хувьцааны тоо 25,870,276.0 ширхэг. Үүнээс нийт 24,505,022 ширхэг саналын эрх бүхий 18 хувьцаа эзэмшигч оролцсон.
	2. Г.Батнасан	Хувьцааны тоо 15 ширхэг	
	3. Д.Доржсүрэн	Хувьцааны тоо 245 ширхэг	
	4. Н.Долгор	Хувьцааны тоо 140 ширхэг	
	5. Т.Лхагвасүрэн	Хувьцааны тоо 24,499,287 ширхэг	
	6. М.Алтан-очир	Хувьцааны тоо 210 ширхэг	
	7. Ө.Өлзиймаа	Хувьцааны тоо 3,666 ширхэг	
	8. Ж.Энхтунгалаг	Хувьцааны тоо 100 ширхэг	
	9. С.Уранчимэг	Хувьцааны тоо 20 ширхэг	
	10. Р.Баасансүрэн	Хувьцааны тоо 5 ширхэг	
	11. Д.Бадамсүрэн	Хувьцааны тоо 70 ширхэг	
	12. Д.Баярсайхан	Хувьцааны тоо 70 ширхэг	
	13. Т.Эх-Оюун	Хувьцааны тоо 81 ширхэг	
	14. Г.Алтан-Оч	Хувьцааны тоо 200 ширхэг	
	15. М.Отгонбаяр	Хувьцааны тоо 200 ширхэг	
	16. Б.Бямбасүрэн	Хувьцааны тоо 79 ширхэг	
	17. Д.Сумъяа	Хувьцааны тоо 350 ширхэг	
	18. М.Баяраа	Хувьцааны тоо 280 ширхэг	
Ирц:	94.72%		

ХЭЛЭЛЦСЭН нь:

1. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай
2. Компанийн 2019 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах тухай
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлтийг батлах тухай
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлж, сонгох тухай
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны зардлын төсвийг батлах тухай
6. Орон сууц хувьчлах тухай

СОНССОН нь:

Д.Ганцэцэг, Тооллогын комиссын дарга: 2020 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирц бүртгэхэд нийт 25,870,276 ширхэг хувьцаанаас 24,505,022 ширхэг хувьцаа эзэмшиж байгаа 18 хувьцаа эзэмшигч ирж хурлын ирц 94.72 хувьтай байгаа тул Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирц хүчин төгөлдөр болохыг мэдэгдэж байна.

Ч.Пүрэвсүрэн, хурлын дарга: МЦХ ХК-ийн 2020 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирц хурал хүчинтэй байх хэмжээнд бүрдсэн байна. Ингээд хурлыг эхлүүлж, хурлын дэгийг танилцуулав.

Ч.Пүрэвсүрэн, хурлын дарга: Хурлын дэгийн дагуу компанийн 2019 оны жилийн тайлан, үйл ажиллагааны үр дүнг танилцуулна уу гэж МЦХ ХК-ийн Гүйцэтгэх захирал М.Алтан-Очирыг индэрт урьж байна.

М.Алтан-Очир, МЦХ ХК-ийн Гүйцэтгэх захирал: Эрхэм хувьцаа эзэмшигчид та бүхний энэ өдрийн мэндийг хүргэе. Энэ жилийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал онцгой нөхцөл байдалд болж байгааг та бүхэн мэдэж байгаа. Дэлхий даяар тархаад байгаа цар тахлын өвчний улмаас улс орнуудад хөл хорио тогтоож, өвчний дэгдэлтийг бууруулахад анхаарч ажиллаж байгаа. Монгол улс энэ онцгой байдлыг үед зөв зохистой арга хэмжээг эрт авч өндөржүүлсэн бэлэн байдлын дэглэмийг мөрдөж, хөл хорио тогтоох шийдвэрүүдийг эрт гаргаж, дагаж мөрдсөний ачаар нөхцөл байдал харьцангуй хяналттай байгаа билээ. Өнөөдөр Монголын цахилгаан холбоо ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа зохион байгуулахдаа Улсын онцгой комиссын зөвшөөрөл авсны үндсэн дээр халдвараас хамгаалах дэглэмийг чанд мөрдөн хурлын танхимуудыг бэлтгэж, зохион байгуулсан. Үндсэн нэг танхим үүнээс гадна гурван танхимыг онлайнгаар видео шууд стриймээр холбож, бүгдэд нь үзүүлж байгаа дээрээс нь хурлын үйл ажиллагаатай холбоотой бичлэгийг хийж баталгаажуулж байгаа. Бүх өрөөнүүдэд аудио болон сонсох нөхцөлийг бүрдүүлсэн. Санал хүсэлтээ хэлэх ширээ, бэлдсэн байгаа. Санал, асуултын микрофоныг бэлдсэн. Аюулгүй байдлыг хангаж ажиллалаа. 2019 оны хийж бүтээсэн ажлын үр дүнгийн талаар танилцуулъя. Монголын цахилгаан холбоо ХК-ийн хамт олон бид 2021 онд тохиох салбарыг 100 жилийн ойг угтан холбоо хөгжил 100 уриан дор хэрэглэгчийн үйлчилгээг сайжруулах, бүтээгдэхүүн үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, технологийн сайжруулалтыг үргэлжлүүлэн хийж, хэрэгжүүлэхэд 2019 оны үйл ажиллагааг чиглүүлэн ажиллалаа.

2019 онд техник технологийн өргөтгөл шинэчлэл хийх, ашиглалт үйлчилгээний хэвийн найдвартай ажиллагааг хангах чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Төлбөр тооцооны нэгдсэн систем буюу биллингийн системийг ашиглалтад орууллаа. Шинэ төлбөрийн систем яагаад нэвтрүүлэх болсон тухай өмнөх хурлуудаар танилцуулсан. Өнөөдөр ашиглаж байсан төлбөр тооцооны систем өнөөдрийн эрэлт хэрэгцээнд шаардлага хангахгүй байсан. Зах зээл дээр багц үйлчилгээ, хэрэглэгч өөрийнхөө хэрэглэсэн хэрэглээгээ хянадаг, хэрэгцээнд тохируулан багцаа сонгодог, байгаа орлогынхоо хэмжээгээр хэрэглээгээ хянадаг ийм биллингийн үйлчилгээ банк санхүү мэдээлэл холбоо бүх газар хэрэгжиж байгаа. Үүнийг хэрэгжүүлэхгүй тохиолдол манай компанийн хэрэглэгч дээрх харилцаа илүү хүнд байдалд орохоор байсан учраас шинэ биллингийн систем орсон. Ингэснээр суурин утас, интернэт, кабелийн телевиз болон интернэт дээр суурилсан телевизийг нэгтгэн нэг үйлчилгээнд оруулах, хэрэглэгч нэг төлбөр төлөх, телефон ярианы дагалдах минуттай багцууд, интернэт суурин утас кабелийн телевизийн хосолсон, гурвалсан хэлбэрээр багцын үйлчилгээг гарган ажиллаж байна. Бид олуулаа гэсэн багцыг гаргасан байгаа. Энэ манай ребрандингийн бүтээгдэхүүн байгаа. Олуулаа гэдэг нь цөмөөрөө телевиздээ үзэх, цөмөөрөө интернэтээ шэйрлэж хэрэглэх, цөмөөрөө телефон утсаа хамран хэрэглэх нөхцөлийг үүсгэж өгч байгаа. Суурин утасны нэг аюултай нь хэдэн минут ярьснаа мэддэггүй, хэн нэгэн үүрэн холбоо руу ярихаар их хэмжээний төлбөр гардаг. Энэ асуудлыг шинэ биллингийн систем шийдсэн. Хэрэглэгчид 100 минутын сүлжээндээ хязгааргүй ярих багцыг гарган ажиллаж байна. Хэрэглэгчийн 40-50 хувь нь багцын үйлчилгээ рүү шилжсэн.

- Үндсэн сүлжээнд ажилладаг европын Алкателийн E10 систем маань 22 дахь жилдээ ашиглалтын хугацаа буюу life time дууссан учраас өнгөрсөн онд телефон станцын системийг унтрааж, оронд нь сүүлийн үеийн NGN станцад шилжүүлэх, ажиллаж байсан NGN станцын хүчин чадал, багтаамжийг нэмэгдүүлэн суурин утасны станцыг шилжүүлэх ажлыг дуусгалаа. Ингэснээр манай үндсэн сүлжээ интернэт дээр суурилагдсан IP суурьтай дараа үеийн суурин телефон холбооны технологи руу шилжсэн. Энэ системээ найдвартай redundant буюу нөөц ажиллагаатай болгохоор ажиллаж манай инженер, техникийн ажилчид өөрсдийн ур чадвараа гарган АТС-45 станц дээр Soft-X 3000 свичыг бүрэн сэргээж, ажиллагааг нь нөөц хэлбэрээр ажиллуулснаар манай үндсэн суурин утасны сүлжээ хоёр станцтай болж найдвартай ажиллагаа 100 хувь хангагдлаа.
- Хэрэглэгчийн санал хүсэлт, гомдол, талархлыг хүлээн авдаг Voice of customer (VOD) буюу хэрэглэгчийн дуу хоолой гэдэг системийг үйл ажиллагаанд шинээр нэвтрүүллээ. Энэ систем нь хэрэглэгчийн санал хүсэлт, гомдол, талархлыг хүлээн авч холбогдох газар, хэлтсүүдэд хуваарилан шийдвэрлүүлэх, хэрэглэгчид шуурхай эргэн мэдээлэх ажиллагааг автоматжуулах цахим шийдлээр шийдсэн. Бүх аймгийг хамруулсан. Ингэснээр манай үйлчилгээг авч байгаа хэрэглэгчийн гомдлыг цахимаар ухаалаг системд бүртгээд, санал гомдол нь бүс, харъяа аймаг сумын холбооны газар луу хуваарилагдаад, эргэн хэрхэн шийдэгдсэн нь автоматаар бүртгэгддэг. VOC системтэй болсноор ажлын давхардлыг арилгасан, хэрэглэгчээ сонсох цахим, ухаалаг платформ бий болгосон.
- Дотоодын телевизүүдийн контентыг төвлөрүүлэх төслийг Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулж байсан. Өнөөдөр мэдээлэл холбооны зах зээл бол илүү хувьсаж байна. Хүн болгонд яриа, интернэт, мэдээллийн технологийн үйлчилгээ ижил тэгш, түрээстэй хүргэгдсэн энэ нөхцөлд өрсөлдөөнд хэн юу үзүүлэх вэ, хэн ямар онцлогтой контентыг үзүүлэхээрээ холбооны компаниуд өрсөлдөөнд орж байна. Дараа үеийн өрсөлдөөний талбар контент хаус, биг дата гэдэг чиглэл рүү өрсөлдөөн, зах зээлийн хуваагдал явагдаж байна. 10 жилийн өмнө хэнд их яриулах уу, хэнд их интернэт хүргэх вэ гэдэг өрсөлдөөн байсан бол одоо хүн болгон хүртээмжтэй болсон дээр хэн юу үзүүлэх вэ тэрний тулд мөнгө төлдөг болж байгаа тул өнгөрсөн оронд бид Улаанбаатар хотын өргөн нэвтрүүлгийн телевизүүдтэй оюуны өмчийн гэрээ хийж, хот орчмын, Монгол оронд байгаа 70 гаруй телевизийн стиудтэй гэрээ байгуулж, контентийн төвлөрсөн сүлжээгээ ашиглан дуу дүрсний өндөр чанартай телевизийн контентийн төвлөрсөн төвтэй болсон. Эхний контент хаустай болж байгаа.
- OTT системийг суурилуулж ажилд оруулахад бэлэн болголоо. Цар тахал намжихаар нэвтрүүлнэ.
- АНДЦХБ-тай Монгол Улсын эрс тэс уур амьсгалд нэвтрүүлэх шилэн кабелийн шинэ технологийн сүлжээг суурилуулах ажлыг өөрсдийн санаачлагаар хийн АНДБЦХБ-аас 225 мянган долларын буцалтгүй тусламжийн дэмжлэгтэйгээр Монголын хөдөө орон нутагт шинэ технологийн шилэн кабелийг элсэрхэг хөрс, хүйтэн бүсэд суурилуулан турших, хэрэглэгчид интернэтийн сүлжээг өргөтгөх энэ төслийг хийн өнгөрсөн онд 25 км шилэн кабелийг Архангай, Баянхонгор, Налайх дүүрэг, Тэрэлж, Горихын чиглэлд суурилуулж ашиглалаа.
- БСШУСЯ-тай байгуулсан боловсролын салбарын нэгдсэн сүлжээнд интернэт урсгал нийлүүлэх, төрийн өмчийн кабелийн дэд бүтцэд хүргэх 44 сум, хот хооронд сувгийн үйлчилгээг үзүүлэх гэрээг сунгаж нийтдээ 2 орчим тэр бум төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн. Гэрээг 2020 онд дахин сургаж, өнөөдөр үйлчилгээгээ хүргэж байна. Энэ үйлчилгээ их чухал байгаа. Монгол Улсын хэмжээнд байгаа 600 гаруй бага дунд сургууль, 300 гаруй цэцэрлэг яслид интернэтийн сүлжээг хүргэж, үйлчилгээг нь 7/24 цагаар хариуцаж байгаа.

- Хар-Уул дүүрэгт байрлах Өмнөд бүсийн Холбооны газрыг жишиг салбар төслийн загварын дагуу тохижуулж үйлчилгээний орчинг сайжруулсан.

- ЛТИ төслийг хэрэгжүүлэхэд бүх орон нутаг, хөдөө, хотыг оролцуулан хийвэл 14-15 сая долларын хөрөнгө оруулалт компанид шаардагдах байгаа. Энэ талаар оны төгсгөлд нилээн сайн ажилласан. Нийлүүлэгч, үйлдвэрлэгчийн зээлээр нилээн шуурхай ажиллаж байсан боловч вирусын тархалтаас болоод ZTE, Huawei компаниудаас холбоо үндсэндээ тасарчлаа. Вирусын байдал бусад компани, бизнес гэлтгүй манай компанид ихээхэн хортой нөлөөлж байна. Ялангуяа гадаад хамтын ажиллагаа зогсонги байдалд орж байна. Гэвч интернэт, и-мэйлээр харьцаж ажиллагаагаа явуулж байна. Гэхдээ бодит байдал хэцүү байна.

Үндсэн үйл ажиллагааны талаар танилцуулъя.

- 2019 онд суурин утасны хэрэглэгчийн тооны төлөвлөгөө 103 хувиар биелсэн. Өмнөх онтой харьцуулахад 1.2 хувийн өсөлттэй ажилласан. Энэ онд шинэ биллингийн багцын үйлчилгээнүүд, хэрэглэгчийн ARPU нилээн өснө. Суурин утсаа ребрандинг хийж Мэдээлэл технологийн салбарын үзэсгэлэнд суурин утсаараа орлоо. Шинэ технологийн утаснуудыг зах зээлд таниулж эрэлт ихтэй байгааг ойлгосон. Өрхийн хэрэглэгчдэд суурин утас ашиглах нь гэнэтийн асуудалд найдвартай гэдгийг ойлгуулж боломжит тарифаар үйлчилгээг санал болгосон. Хэрэглэгч бууралттай байгаач энэ талаар Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын дэмжлэгтэйгээр 26 дугаарлалтай төрийн суурин телефон утасны хэрэглэгчид манай компанид шилжин ирж орлого, ашиглалт үйлчилгээг нь хангаж байна. Энэ бол хувьцаа эзэмшигч төрийн төлөөлөл маань биднийг дэмжиж байгаагийн тод илрэл юм.

Мөн Харилцаа холбооны зохицуулах хороо, Иргэний нисэхийн ерөнхий газар, Зам тээврийн яамтай хамтран уйгагүй ажилласан хүрээнд Иргэний нисэхийн ерөнхий газрын харъяа газруудын 28XXXX дугаарыг манай суурин утасны сүлжээнд, 900 гаруй утсыг шилжүүллээ. Ингэснээр 28 дугаар байхгүй болж 7128 гэсэн шинэ ргефх гаргалаа. Сар тутам тогтмол орлогыг авч байгаа. Энэ бол харилцаа холбооны салбарт хамтран ажиллах шинэ түлхэц болсон. Иргэний нисэхийн байгууллага, онгоц агаарын навигаци бодит ажиглалт, агаарын тээврийг зохицуулах ажлаа илүү түлхүү анхаарч, телефон утас, хэрэглээний ажлаа манай компанид даатган төлбөрөө төлдөг шинэ хэлбэр лүү шилжсэн байна. Дараагийн томоохон ажил бол том уул уурхайн компани Эрдэнэтийн ГОК-ийн үйл ажиллагааг авахаар хөөцөлдөж байгаа. Онцгой байдлаас болж ажил урагш явахгүй байна. Тэдний 1000 гаран телефон цэгийн үйлчилгээг манай компани хариуцан хямд төсөр харилцан ашигтай зардал хэмнэсэн маягаар явах ажлыг хөөцөлдөж байна.

- Интернэтийн үйлчилгээ орлогын бүтэц нилээн том байр эзэлж байна. Тайлант хугацаанд орлогын төлөвлөгөө 99.7 хувьтай биелсэн. Нэг хэрэглэгчээс олох дундаж орлого 7 хувь өссөн. Хэрэглэгчийн тооны төлөвлөгөө 85 хувийн биелэлттэй, интернэтийн хэрэглэгчийн тоо 19 мянга байна. Интернэт дээр нэг хүндрэл байгаа. Энэ юу вэ гэхээр манай интернэтийн зах зээлээ тэлэхийг тулд хурднаас гадна өрсөлдөхүйц үнэ тарифыг хэрэглэгчид хүргэх, хурдны багцын сонголтыг зах зээлд нэвтрүүлэхэд анхаарах хэрэгтэй байгаа. Өнөөдөр интернэтийн зах зээл дээр өрсөлдөөн их байна. Юнитель, Скайтель групп, Жи-мобайл групп, Мобиком мөн ISP компаниуд 200-300 орчим байна.

Манайх мөн сайн ажиллаж байна. Давуу нь хүн хүч, газар орон нутгийн үйлчилгээний салбар байна. Өрсөлдөж байна. Гол нь технологийн хоцрогдол байна. Зэс кабель нь 2 Мб/сек хурд гаргадаг. Өнөөдрийн шаардлагыг хангахгүй байна. Хоёрдугаарт зэс кабель нь Мэдээлэл холбооны сүлжээ компанийн өмчид байдаг. Сүүлийн 10 жил зэс кабелидаа хөрөнгө оруулалт хийгээгүй. Бид өөрийн гэсэн үндсэн өндөр хурдны өргөн зурвасын Broadband сүлжээг

байгуулах, өөрийн сүлжээгүй бол явахгүй байна. Энэ жилээс бага багаар өөрийн сүлжээ байгуулах хөрөнгө оруулалтыг хийж байгаа. Өнгөрсөн онд 21 аймагт шилэн кабелийн цагирган сүлжээг байгуулж GPON тавилаа. Энэ жил Улаанбаатарт аажмаар хийж байна. Ойрын 3-5 жилдээ бүх зэс кабель дээр байгаа сүлжээгээ шилжүүлэхээс өөр арга байхгүй. Өнгөрсөн онд 70.9 км шилэн кабелийг суурилуулж, 233 GPON цэгийн үйлчилгээг нээсэн байгаа.

Өрсөлдөгчид хотод 500 км, орон нутаг 5-6000 км шилэн кабельтай байж зах зээлд өрсөлдөж байна. Интернэтийн үнэ жил ирэх тусам буурч байна. Монгол Улсын интернэтийн жилийн хэрэглээ 10 жилийн өмнө 10 Гб/сек байлаа, одоо 100 Гб/сек болж байна. Энэ юу гэсэн үг вэ гэвэл 10 литрийн бетоноор ус авч байсан бол одоо том юмкосттой машинаар авч байгаатай адилхан. Их авахын хирээр гадаадаас авах интернэтийн үнэ буурч байна. Интернэтийн хэрэглээний үнэ бол тодорхойгүй, дандаа багцаар авч байна.

ADSL-ээ бас багцалж байна. Манай компанийн нэг онцлог бол дата хязгаарладаггүй. Хязгааргүй хаазаа дарах хэмжээнд интернэт явуулдаг. Энэ онцлогоо хэрэглэгчид түлхүү хүргэж байгаа. Интернэт гэдэг бол уулын самар зардаг шиг байна.

Интернэтийн зардлыг нийт дүнгээрээ 20 хувь бууруулж байна. Энэ хэрэглэгчид үр ашгаа өгч байгаа. Хямдарч очиж байгаа, хурд нь нэмэгдэж байгаа. Интернэтэд суурилсан телевизийн үйлчилгээг хүргэх эрхзүйн зөвшөөрлийг авсан.

Өнгөрсөн онд КаТВ-ийн үйлчилгээ 96 хувийн биелэлттэй байлаа. Өмнөх оноос 27 хувийн биелэлттэй байлаа. Нэг хэрэглэгчээс олох дундаж орлого 17 хувиар өссөн. Хэрэглэгчийн тоо 15 мянга руу дөхсөн. Энэ бол боломжийн тоо байгаа. SBS сувгийн орон нутагт давуу эрхтэй үзүүлж байгаа. ORT ийн 3 суваг, цаашид 6 сувгийг авна. Бүгд оюуны өмчийн зөвшөөрөлтэй байгаа. ОХУ-ын ORT сувагтай гэрээ хийхэд Монгол дахь Оросын элчин сайдын яам маш их тус хүргэсэн. Бидэнд Хувьцаа эзэмшигчдийн дэмжлэг их хэрэгтэй байна. Төр гэдэг талаас нь биш бодлого дэмжлэг их хэрэгтэй байгаа. Бид ерөнхийдөө тодорхойлж гаргаад асуудлаа тавьж байгаа. Өнгөрсөн онд хийсэн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг сайн тооцож байгаа. Төлөөлөн удирдах зөвлөл ч гэсэн хөрөнгө оруулалтын үр дүн, эргэн төлөлтийг төсөл тус бүр дээр нь тооцож, баталгаажуулж явж байгаа. Энэ нь хэрэгжүүлж байгаа төслийн баг, удирдлагын багт сайн нөлөө үзүүлж байгаа. Зөв хөрөнгө оруулалт хийх асуудлыг маш сайн анхаарч өрсөлдөх чадвар, ажиллах чадвар, тэмүүллийг авчирч байгаа гэдгийг онцлон тэмдэглэе.

Компанийн өнөөдрийн нөхцөл байдал хүнд байна. Компанийн 1-р улирлын тайлан гарсан. Энэ 2019 онтой холбоотой биш боловч цар тахалтай холбоотой орлого буурч байна. Энэ байдал цаашдаа үргэлжилбэл нилээн хүндрэх шинжтэй байна. Кабелийн телевиз суурилуулъя гэхээр гэртээ оруулахгүй байна. Энэ бас зөв. Томоохон хотхон суурингууд аюулгүй байдлаа бодоод үйлчилгээ оруулахгүй байна. Том хэрэглэгч нар суурь хураамжаа чөлөөлөөч, интернэтийн үнэ тарифаа царцаагаач, нэг, хоёр сарын төлбөрөөс чөлөөлөөч гээд бичгээ өгч байна. Жишээ нь Оюутолгой, Шангирлла гэх мэт.

2020 онд хэрэглэгчийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, хувьцааныхаа үнэ цэнийг нэмэгдүүлэх, хэрэглэгчийн үйлчилгээгээ төрөлжүүлэх, багцын үйлчилгээ, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ зах зээлд нэвтрүүлэх, орлогын эх үүсвэрийг баталгаажуулах, үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлэх зорилго тавин ажиллаж байна. Цар тахал үргэлжилбэл бид зардлаа хэмнэнэ. Явах суух ажлаа багасгана. Машин тэргээ цөөлнө. Одоо бид том машинуудаа зогсоож, зөвхөн жижиг тэрэгнүүдээ ажиллуулж байна.

Ажилчин бүр борлуулагч болох том ажлыг 2 жил хийж байна. Манай компани төрийн том компани, төрийн үйлчилгээн дээр төвлөрч байсан учраас хэрэглэгч рүүгээ зорьж явах ажил муу байсан. Зөвхөн угтаж авч үйлчилдэг. Ирэхээр нь салбар дээр уулздаг. Энэ ажлыг өнгөрсөн жилээс шат дараатай хүмүүсээ мониторинг хийж, хүмүүсийнхээ сэтгэл зүйг өөрчилж өрсөлдөөнд бэлдүүлж, явж орлого оруулдаг, явж хэрэглэгчийг урамшуулдаг, хэрэглэгчийг өөртөө татдаг сэтгэлгээтэй болгож ажиллуулж байна.

Шилэн кабелийн сүлжээгээ өргөтгөнө, өөрийн сүлжээтэй болох ажлыг тууштай хийнэ. Шинээр гарч байгаа ОТТ буюу интернэт дээр суурилсан кабелийн телевизийн платформ, Кабелийн ТВ-ээ гурвалсан багцын үйлчилгээнд оруулж үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэх энэ ажлыг үргэлжлүүлэн хийнэ.

Салбарын түүхт 100 жилийн ой манай компанийн 100 жилийн ой цуг тохиож байгаа. Энэ ойгоо Монголын цахилгаан холбоо ХК-ийн хамт олон бид хувьцаа эзэмшигч та бүхнийхээ дэмжлэгтэйгээр компанийн бизнесийн үйл ажиллагааг сайжруулж үнэ цэнийг нэмэгдүүлэх хүндтэй зорилгын төлөө хичээн ажиллах болно. Та бүхэнд анхаарал тавьсанд баярлалаа. Та бүхэнд амжилт хүсэе.

Илтгэлийн төгсгөлд Гүйцэтгэх захирал М.Алтан-Очир ОТТ системийг талаар танилцууллаа.

Ч.Пүрэвсүрэн, хурлын дарга: Гүйцэтгэх захирал Алтан-Очиртоо баярлалаа. Хэлэлцэх асуудлын дарааллын дагуу компанийн 2019-ны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг танилцуулахыг ТУЗ-ийн нарийн бичиг Цэцэгмааг индэрт урьж байна.

Х.Цэцэгмаа, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга: Компанийн 2019-ны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 4 дүгээр сарын 06-ны өдрийн 01 тоот тогтоолыг уншиж танилцуулав.

Ч.Пүрэвсүрэн, хурлын дарга: Дараагийн хэлэлцэх асуудал компанийн 2019 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг танилцуулна уу гэж Нягтлан бодох бүртгэлийн албаны дарга Л.Болдбаатарыг индэрт урьж байна.

Л.Болдбаатар, НББА-ны дарга: Компанийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг танилцуулав. Танилцуулгад Үндэсний аудитын газрын Аудитын гэрчилгээ, компанийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх Санхүүгийн байдлын тайлан, Орлогын дэлгэрэнгүй тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайланг уншиж танилцууллаа.

“Үндэсний аудитын газрын 2020 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 06/786 тоот албан бичиг Монголын цахилгаан холбоо ХК-ийн Гүйцэтгэх захирал М.Алтан-очир танаа

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18. 2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг

материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Монголын цахилгаан холбоо ХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц. Наранчимэг гэсэн байна.

- Санхүү байдлын тайлан - Хөрөнгө эргэлтийн хөрөнгө 11 тэрбум 793 сая 907 мянган төгрөг, эргэлтийн бус хөрөнгийн дүн 30 тэрбум 289 сая 710 мянган төгрөг, нийт хөрөнгийн дүн 42 тэрбум 83 сая 617 мянган төгрөг. Өр төлбөр ба эздийн өмч – Богино хугацаат өр төлбөр 3 тэрбум 114 сая 657 мянган төгрөг, урт хугацаат өр төлбөр 4 тэрбум 370 сая 849 мянган төгрөг, өр төлбөрийн нийт дүн 7 тэрбум 485 сая 506 мянган төгрөг, эздийн өмч 2 тэрбум 587 сая 27 мянган төгрөг үүнээс төрийн өмч 2 тэрбум 449 сая 928 мянган төгрөг, хувийн өмч 137 сая 98 мянган төгрөг, эздийн өмчийн дүн 34 тэрбум 598 сая 11 мянган төгрөг, өр төлбөр ба эздийн өмчийн дүн 42 тэрбум 83 сая 617 мянган төгрөг байна.

- Орлогын дэлгэрэнгүй тайлан – Борлуулалтын орлого 18 тэрбум 296 мянган төгрөг, борлуулалтын өртөг 15 тэрбум 906 сая 694 мянган төгрөг, түрээсийн орлого 890 сая 107 мянган төгрөг, хүүний орлого 706 сая 802 мянган төгрөг, бусад орлого 14 сая 591 мянган төгрөг, борлуулалт, маркетингийн зардал 553 сая 856 мянган төгрөг, ерөнхий ба удирдлагын зардал 2 тэрбум 475 сая 187 мянган төгрөг, санхүүгийн зардал 60 сая 161 мянган төгрөг, бусад зардал 545 сая 109 мянган төгрөг, гадаад валютын ханшийн зөрүүний олз 19 сая 27 мянган төгрөг, үндсэн хөрөнгө данснаас хассаны олз 42 сая 881 мянган төгрөг, татвар төлөхийн өмнөх ашиг 132 сая 696 мянган төгрөг, орлогын татварын зардал 70 сая 680 мянган төгрөг, татварын дараах ашиг 62 сая 16 мянган төгрөг байна.

- Өмчийн өөрчлөлтийн тайлан - 2017 оны 12-р сарын 31-ны үлдэгдлээр 2 тэрбум 587 сая 27 мянган төгрөгийн өмч байсан, эздийн өмчийн бусад хэсэг 117 сая 678 мянган төгрөг, хуримтлагдсан ашиг 26 тэрбум 244 сая 235 мянган төгрөг, нийт дүн 28 тэрбум 948 сая 941 мянган төгрөг байна. 2018 оны 12-р сарын 31-ны үлдэгдлээр өмч 2 тэрбум 587 сая 27 мянган төгрөг, эздийн өмчийн бусад хэсэг 8 тэрбум 242 сая 516 мянган төгрөг, хуримтлагдсан ашиг 22 тэрбум 839 сая 690 мянган төгрөг, нийт эздийн өмч 33 тэрбум 666 сая 234 мянган төгрөг болж байна. 2019 оны 12-р сарын 31-ны байдлаар өмч 2 тэрбум 587 сая 27 мянган төгрөг, хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл 999 сая 486 мянган төгрөг, эздийн өмчийн бусад хэсэг 8 тэрбум 247 сая 270 мянган төгрөг, хуримтлагдсан ашиг 22 тэрбум 764 сая 326 мянган төгрөг, нийт өмч 34 тэрбум 598 сая 110 мянган төгрөг байна.

- Мөнгөн гүйлгээний тайлан - Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ мөнгөн орлогын дүн 22 тэрбум 561 сая 772 мянган төгрөг, бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого 19 тэрбум 338 сая 722 мянган төгрөг, мөнгөн зарлагын дүн 19 тэрбум 325 сая 590 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн нь 3 тэрбум 236 сая 182 мянган төгрөг байна. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ мөнгөн орлогын дүн 1 тэрбум 36 сая 129 мянган төгрөг, мөнгөн зарлагын дүн 5 тэрбум 755 сая 701 мянган төгрөг, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн 4 тэрбум 719 сая 572 мянган төгрөг. Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ мөнгөн орлогын дүн 368 сая 887 мянган төгрөг, мөнгөн зарлагын дүн 413 мянга 500, санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн 368 сая 473 мянган төгрөг. Валютын ханшийн зөрүү 5 сая 964 мянган төгрөг, Бүх цэвэр мөнгөн гүйлгээ хасах 1 тэрбум 108 сая 952 мянган төгрөг, мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл 2 тэрбум 95 сая 624 мянган төгрөг, мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл 986 сая 671 мянган төгрөг болж байна.”

Анхаарал хандуулсанд баярлалаа

Ч.Пүрэвсүрэн, хурлын дарга: За Болдбаатар даргад баярлалаа. Дараагийн хэлэлцэх асуудлаар ТУЗ-ийн Аудитын хорооноос компанийн санхүүгийн тайлангийн талаар гаргасан дүгнэлтийг танилцуулахаар индэрт ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дарга, ТУЗ-ийн хараат бус гишүүн Ц.Норовжамцыг урьж байна.

Ц.Норовжамц, ТУЗ-ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн Аудитын хорооны дарга: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. ТУЗ-ийн Аудитын хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн Ц.Норовжамц миний бие, гишүүдээр ТУЗ-ийн ердийн гишүүн Ж.Цогтбаяр, ТУЗ-ийн хараат бус гишүүн Л.Болормаа нар ажиллаж байна.

2019 онд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Азийн хөгжлийн сан, Компанийн засаглалын хөгжлийн төвөөс компанийн засаглалын үнэлгээ хийхэд Аудитын хороо бас оролцсон. Үнэлгээний багынхангай уулзалт хийж, тайлангийн хурал, ахисан түвшний сургалтад сууж, шалгалтыг амжилттай өгсөн. Компанийн засаглалын үнэлгээгээр Монголын цахилгаан холбоо ХК нь 2 дугаар байр эзэлсэн нь компанийн засаглалын түвшин бусад компаниудаас сайн байгааг харууллаа.

2019 онд Аудитын хороо 4 удаа хуралдаж, Засгийн Газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас ирсэн албан тоотын дагуу, мөн хараат бус аудитын компанийг сонгон шалгаруулах тухай, санхүүгийн тайлангийн тухай тус тус дүгнэлт гаргалаа. 2019 оны жилийн санхүүгийн тайланд аудит хийх хараат бус хуулийн этгээдийн сонгон шалгаруулалтад дөрвөн компани оролцож Монголиан бизнес рейтинг аудит ХХК-ийн тендер өндөр үнэлгээ авч хараат бус аудит хийсэн.

Аудитын хороо 2019 оны эхний хагас жил болон жилийн эцсийн санхүүгийн тайлан, тайлбар тодруулга, ерөнхий болон мөнгөн хөрөнгө зэрэг холбогдох журналыг татаж авч үзлээ. Мөн хөрөнгө оруулалтын тайланг хагас бүтэн жилээр гаргуулан авч танилцаж үзлээ.

Дотоод хяналт, шинжилгээ үнэлгээний албаны ажлын тайлангуудтай танилцаж, албаны дарга, мэргэжилтэнтэй уулзсан.

Монголын Цахилгаан Холбоо ХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн аудитлагдсан тайлантай танилцаж, дүгнэлт хийлээ. Санхүүгийн үйл ажиллагааны үр дүн дараах гүйцэтгэлтэй байлаа.

1. Санхүүгийн тайлангийн талаар: Орлого: 2019 онд 21,136.8 сая төгрөгийн нийт орлоготой ажиллахаас гүйцэтгэлээр 19,688.5 сая төгрөгийн нийт орлоготой ажиллаж, нийт орлогын төлөвлөгөө 93 хувийн биелэлтэй буюу 1,448.4 сая төгрөгөөр дутуу биелсэн.

Үндсэн үйл ажиллагаанаас 20,124.2 сая төгрөгийн орлоготой ажиллахаас гүйцэтгэлээр 18,890.4 сая төгрөгийн орлоготой ажиллаж, төлөвлөгөө 94 хувийн биелэлттэй буюу 1,233.8 сая төгрөгөөр тасарсан. Үүнд олон улсын ярианы үйлчилгээний орлого 89.6 сая төгрөг, суурин утасны үйлчилгээний орлого 1,077.1 сая төгрөг, интернэт үйлчилгээний орлого 21.3 сая төгрөг, кабелийн телевизийн үйлчилгээний орлого 23.3 сая төгрөг, лавлах дуудлага үйлчилгээний орлого 91.8 сая төгрөгөөр тус тус тасарч биелсэн байна.

Үндсэн бус үйл ажиллагаанаас 1,012.6 сая төгрөгийн орлоготой ажиллахаас гүйцэтгэлээр 798.1 сая төгрөгийн орлоготой ажиллаж, төлөвлөгөө 79 хувийн биелэлттэй байна.

Зардал: 2019 онд төлөвлөгөөгөөр 21,087.9 сая төгрөгийн нийт зардалтай ажиллахаас гүйцэтгэлээр 19,626.4 сая төгрөгийн зардал гарган 93 хувийн биелэлттэй. 1,461.5 сая төгрөгийн зардал хэмнэсэн үзүүлэлттэй байна. Үүнд, үндсэн үйл ажиллагааны зардал 1,024.3 сая төгрөг хэмнэсэн ба тухайлбал интернэт сувгийн түрээс 267.5 сая төгрөг, КаТВ сувгийн түрээс 160.2 сая төгрөг, харилцан холболтын зардал 120.4 сая төгрөг, цалин болон НДШ-ийн зардал 192.4 сая төгрөг, зар сурталчилгаа 57.2 сая төгрөг, байрны түрээсийн зардал 28.7 сая төгрөг, элэгдлийн зардал 173.0 сая төгрөг хэмнэж, бусад үйл ажиллагааны зардлуудыг төлөвлөсөн дүнгээр зарцуулсан байна.

Ашиг: Тайлант хугацаанд 48.9 сая төгрөгийн ашигтай ажиллахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 62.0 сая төгрөгийн ашигтай ажиллаж, ашигт ажиллагаа сайжирсан.

Авлага. Авлага өмнөх оноос 425.5 сая төгрөгөөр буурч, нийт 2,166.4 сая төгрөг болсон байна. Дансны авлага буюу хэрэглэгчийн авлагыг 166.7 сая төгрөгөөр, бусад авлагыг 273.5 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

Богино хугацаат өр төлбөр: Өглөг өмнөх оноос 275.3 сая төгрөгөөр өсч 3,114.6 сая төгрөг болсон байна. Өглөг өссөн нь Радио давтамж ашиглах тусгай зөвшөөрлийн нэг удаагийн төлбөр болох 900.0 сая төгрөгийн өглөг үүссэн ба 2010-2014 оны хоорондох татварын маргаантай холбоотой 533.2 сая төгрөгийн татварын өр төлөгдсөн зэргийн зөрүү нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө: Үндсэн хөрөнгө 2,801.4 сая төгрөгөөр өсч 21,028.5 сая төгрөг болсон байна. Үндсэн хөрөнгө өссөн нь GPON сүлжээний өргөтгөл 1,545.9 сая төгрөг, кабель шугамын өргөтгөл болон кабелийн телевизийн технологи тоон системд шилжсэнтэй холбоотой 1,781.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Биет бус хөрөнгө 795.7 сая төгрөгөөр өсч 9,133.7 сая төгрөг болсон байна. Энэ бол радио давтамж ашиглах тусгай зөвшөөрлийг бүртгэлд тусгасантай холбоотой байна.

Хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны талаар: 2019 онд хийгдэх хөрөнгө оруулалт 5,108.5 сая төгрөгөөр батлагдсан бөгөөд гүйцэтгэл 3,945.3 сая төгрөг буюу 77 хувийн биелэлттэй байна. IGW станц өргөтгөх төслийг төсвийн тодотголоор цуцалсан бөгөөд тоног төхөөрөмжийн нөөцийг бүрэн ашиглах, холболтыг оновчтой зохион байгуулах, хуучин тоног төхөөрөмжүүдийг сэргээн засварлах ажлыг үе шаттай зохион байгуулснаар хэмнэлт гарган ажилласан. Бусад хөрөнгө оруулалтын төслүүдийг амжилттай хэрэгжүүлж дуусгасан байна.

Монголын цахилгаан холбоо ХК нь 2019 оны худалдан авах ажиллагааг цахимаар нээлттэй тендер шалгаруулалт 5 удаа, шалгаруулалтын онцгой журмаар буюу харьцуулалтын аргаар 21 удаа тендер шалгаруулалт зохион байгуулж, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30.4.3 болон 34.1.2 дахь заалтыг үндэслэн шууд гэрээ байгуулах аргаар 3, шууд худалдан авалт хийх аргаар 251 удаа 179 нэр төрлийн бараа материал, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл худалдан авсан байна. Шилэн дансны нэгдсэн системд 2019 онд 6 нэр төрлийн мэдээллийг 62 удаа байршуулж мэдээлэхээс 7 мэдээллийг хугацаа хожимдуулж мэдээлсэн байна гэж хараат бус аудитын тайланд дурдагджээ.

2019 онд их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулагдаагүй буюу үүсээгүй.

Дүгнэлт: МЦХ ХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлэгдсэн тул “зөрчилгүй” санал дүгнэлтийг Үндэсний аудитын газраас гаргасан нь компанийн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааг хэвийн байгааг харуулж байна.

2019 онд компанийн үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө биелээгүй боловч зардлыг хэмнэж ажиллаж, ашгийн хэмжээг нэмэгдүүлсэн байна. Мөн авлага, бараа материалын үлдэгдэл буурсан, өмнөх өглөг буурсан үзүүлэлтүүд гарсан байна.

2018 онд Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооноос 6 зөвлөмж өгснөөс 5 зөвлөмжийг биелүүлж, өр төлбөрийг 275.3 сая төгрөгөөр өссөн шалтгаан нь радио давтамж ашиглах тусгай зөвшөөрлийн нэг удаагийн төлбөр болох 900.0 сая төгрөгийн өглөг үүссэнээс шалтгаалжээ.

Мөн 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж өгсөн ба зөвлөмжийн хэрэгжилт 100 хувь байна.

Аудитын хорооноос өгөх зөвлөмж: - Үндэсний аудитын газраас өгсөн 3 зөвлөмжийг заасан хугацаанд биелүүлж, хүргүүлж тайлагнах нь зүйтэй. - Аудитын тайлангаар залруулагдсан алдааг дахин давтан гаргахгүй байх. - Шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээллүүдийг цаг тухай бүр мэдээлж байх. - Хуримтлагдсан авлагыг барагдуулах, өр шинээр нэмж үүсгэхгүй байх талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах. - 2018-2019 онуудад хийгдсэн хөрөнгө оруулалтын үр дүн, өгөөж тооцоолсон хэмжээнд байгаа эсэхэд шинжилгээ хийж цаашдын төлөвийг тодорхойлох. - Дотоод аудит, шинжилгээ үнэлгээний алба нь аудитын хороотой хамтарч ажиллах шаардлагатай байна гэсэн зөвлөмжийн өгч байна.

Ч.Пүрэвсүрэн, хурлын дарга: Норовжамц гишүүнд баярлалаа. Хурлаар хэлэлцэх асуудлын дөрөвт Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлж, сонгох тухай асуудал байгаа. Хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээллийг танилцуулна уу хэмээн ТУЗ-ийн нарийн бичиг Цэцэгмааг индэрт урьж байна.

Х.Цэцэгмаа, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга: Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нэр дэвшигчдийн талаар танилцуулъя. Эхлээд хэлэлцэх асуудлын үндэслэлийг танилцуулъя.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2020 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг чөлөөлж, томилох тухай асуудлыг хэлэлцүүлэхээр санал оруулсан. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 4 сарын 23-ний өдрийн “Монголын цахилгаан холбоо хувьцаа эзэмшигчдийн хуралд санал өгөх тухай” А-1/708 тоот албан бичгээр “Монголын цахилгаан холбоо” хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүн Д.Ариунтуяа /Хууль зүй, дотоод хэргийн яамны хэлтсийн дарга/, Ц.Баяр-Эрдэнэ /Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хэлтсийн дарга/ нарыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээс чөлөөлж, гишүүнээр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн Ц.Шинэхүү, Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтсийн мэргэжилтэн М.Лхагважав нарыг томилуулах саналыг ирүүлсэн байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшиж байгаа хүмүүсийн талаар танилцуулья. Нэгдүгээрт, ТУЗ-ийн дарга, ТУЗ-ийн Нэр дэвшүүлэх хорооны дарга Цэнддаваагийн Баяр-Эрдэнэ. Боловсрол: Улс төр судлаач-нийгмийн ухааны багш, төрийн удирдлагын менежер мэргэжилтэй. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтсийн даргаар ажилладаг. Дараагийн гишүүн ТУЗ-ийн ердийн гишүүн, ТУЗ-ийн Цалин, урамшууллын хорооны дарга Доржгочоогийн Ариунтуяа. Боловсрол: Хуульч, хуулийн ухааны магистр зэрэгтэй. Одоо Хууль зүй, дотоод хэргийн яам, Захиргааны хэм хэмжээний актын хяналт, бүртгэлийн хэлтсийн даргаар ажилладаг. Хоёрдугаарт шинээр нэр дэвшиж буй нэр дэвшигчдийг танилцуулья. Цэрэннадмидын Шинэхүү ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигч Боловсрол: Цахилгааны автоматикийн инженер, Төрийн удирдлагын магистр, Нийгмийн ухааны Докторант. Ажлын туршлагын хувьд 2000-2001 онд Дорнодын Дулааны цахилгаан станц, Цахилгаан цех, Элжийн мастер, Засварын инженер, 2002-2005 онд Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем ТӨХК инженер 2007-2016 Нийслэлийн өмчийн харилцааны газар мэргэжилтэн, 2016 оноос Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс, мэргэжилтэн ажилтай. Дараагийн ердийн гишүүнд нэр дэвшигч Мандалын Лхагважав Боловсрол: Нягтлан бодогч, мэдээлэл зүй, бакалавр, Ажилласан байдал: 2017-2019 ТӨБЗГ, Захиргаа, хууль зүйн хэлтэс, мэргэжилтэн, 2020 оноос Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс, мэргэжилтнээр ажиллаж байгаа.

Эцэст нь санал хураалтын талаар танилцуулья. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж байгаа 6 гишүүдээс 2 гишүүнийг чөлөөлж, шинээр сонгох тул 4 нэр дэвшигчдээс зөвхөн 2 нэр дэвшигчдэд кумулятив аргаар санал өгнө. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Ч.Пүрэвсүрэн, хурлын дарга: Дараагийн асуудал Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны зардлын төсвийг батлах тухай асуудал байгаа.

Х.Цэцэгмаа, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга: Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны зардлын төсвийн төсөл гурван төрөлтэй байгаа. Үүнд цалин, холбоо, тээврийн зардалд 70 сая 440 мянган төгрөг, бичиг хэрэг, хурлын зардалд 3 сая 260 мянган төгрөг, томилолт, сургалтын зардал 29 сая 155 мянган төгрөгийн нийт 102 сая 855 мянган төгрөгийн зардал төсөвлөсөн. Зардлын дэлгэрэнгүй Цалин, холбоо, тээврийн зардал гурван бүлэгтэй ТУЗ-ийн гишүүний цалин нийт 9 гишүүн, сарын цалин 605 мянган төгрөг жилийн хугацаанд 65 сая 340 мянган төгрөг, ТУЗ-ийн нарийн бичгийн даргын цалин нэг хүн сарын цалин 385 мянган төгрөг, жилд 4 сая 620 мянган төгрөг, ТУЗ-ийн нарийн бичгийн даргын холбооны зардалд сар бүр 40 мянган төгрөг, жилийн 480 мянган төгрөг төсөвлөсөн байна. Бичиг хэрэг, хурлын зардал мөн гурван хэсэгтэй бичиг хэрэг, хэвлэмэл материал, цай, кофены зардал сард 150 мянган төгрөг, жилдээ 1 сая 800 мянган төгрөг, хурал зохион байгуулах байрны түрээсд 800 мянган төгрөг, бусад зардалд 660 мянган төгрөг төсөвлөсөн. ХХМТ-ийн салбар болон дэд

бүтэц, бусад холбогдох салбарын туршлага судлах, хурал, үзэсгэлэнд оролцох, томилолтын зардал мөн гурван хэсэгтэй. Тээврийн зардал долоон хүнийг хамруулахаар төлөвлөж нэг хүний 1 сая 600 мянган төгрөг нийт 11 сая 200 мянган төгрөг, зам хоног өдөрт 135 мянган төгрөг, 4 сая 725 мянган төгрөг, зочид буудал хоногийн 378 мянган төгрөг нийт 13 сая 230 мянган төгрөг төсөвлөсөн байгаа. Нийт зардлаараа 102 сая 855 мянган төгрөг болж байна. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Ч.Пүрэвсүрэн, хурлын дарга: Дараагийн хэлэлцэх асуудал орон сууц хувьчлах тухай байгаа. Хувьчлах орон сууц хувьчлах тухай танилцуулгыг хуулийн ахлах мэргэжилтэн Азбаяр танилцуулна.

Ж.Азбаяр, хуулийн ахлах мэргэжилтэн: Эрхэм хувьцаа эзэмшигч та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Хувьчлах орон сууц хувьчлах тухай танилцуулъя. Юуны өмнө хурлын материалд дэлгэрэнгүй мэдээллүүд байгаа гэдгийг онцолж хэлье. Нэгдүгээрт үндэслэл хэсгийг танилцуулъя. Монгол улсын орон сууц хувьчлах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 6 дугаар зүйлийн 4 дэх хэсэг заасны дагуу орон сууцыг хувьчлах хууль эрхзүйн үндэслэл байна. Мөн Монгол улсын иргэний хуулийн холбогдох заалтын дагуу хууль ёсоор эзэмшиж байгаа ажилтан хүсэлтээ гаргаж байгаа. Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх, 76 дугаар зүйлийн 76.1.3 дахь хэсэгт заасныг үндэслээд төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хурлаар дээрх асуудлыг хэлэлцээд дэмжиж, эцэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэдэг тогтоол гарсан. Орон сууцанд амьдарч байгаа Монголын цахилгаан холбоо ХК-ийн инженер техникийн ажилтнууд хүсэлтээ 2014 оноос хойш Гүйцэтгэх удирдлага болон Төлөөлөн удирдах зөвлөлд удаа дараа хандаж гаргасан байдаг. Тухайн ажиллагсдын харьяалагдах газар нэгж нь хурлаараа хэлэлцээд эдгээр хүмүүст хувьчлан олгох нь зүйтэй гэдэг холбогдох баримт бичгүүдийг ирүүлсэн байдаг. Хоёрдугаарт саналыг танилцуулъя. Монголын цахилгаан холбоо ХК нь BTS станц суурилуулах зорилгоор орон сууц худалдан авч нэг өрөөнд нь станцаа байрлуулан, хажуу өрөөнд нь инженер, техникийн ажилтнаа амьдруулж байсан. Энэ нь станцын техникийн ашиглалт үйлчилгээг байнгын хяналттай, гарсан гэмтэл саатлыг шуурхай засварлуулан ажиллуулдаг байсан.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2012 оны 47 дугаар тогтоолоор уг WLL системийн станцуудыг татан буулгасан. Түүнээс хойш энэ инженер, техникийн ажилтнууд тухайн орон сууцны ашиглалтын зардал, урсгал засварыг өөрөө хариуцан, хууль ёсоор эзэмшээд амьдарч байна. Энэ компанид олон жил үр бүтээлтэй ажилласан инженер техникийн ажилтныг цаашид тогтвор суурьшилтай ажиллуулах, нэг талдаа ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэх, нөгөө талд нь Монголын цахилгаан холбоо ХК-ийн хувьцаа эзэмшигч та бүхний хөрөнгийг хамгаалж эдгээр орон сууцыг үлдэгдэл өртгөөр нь тухайн инженер техникийн ажиллагсдад хувьчлан олгох, ийм саналыг та бүхэнд танилцуулж байна. Гуравдугаарт инженер техникийн ажилчдыг танилцуулъя. Цогзолын Нанжид Радио холбооны инженер мэргэжилтэй, Төвийн бүсийн холбооны газарт Кроссын инженерээр ажилладаг. Монголын цахилгаан холбоо ХК-д 30 дахь жилдээ ажиллаж байна. Нанжид нь Төрийн Холбоо, Яам Тусгай Газруудын суурин утас, интернэтийн найдвартай ажиллагааг хариуцан ажиллаж байна. Өнгөрсөн 30 жилийн хугацаанд шилдэг сайн ажилласан инженер, техникийн ажилтан байна. Мягмарын Баярсайхан, Цахилгаан холбооны инженер мэргэжилтэй, Технологийн газрын Техникийн ашиглалт үйлчилгээний албаны ахлах инженерээр ажиллаж байна. Монголын цахилгаан холбоо ХК-д 18 дахь жилдээ ажиллаж байна. М.Баярсайхан нь Монголын цахилгаан холбоо ХК-ийн станцууд болон өндөр хурдны сүлжээ (GPON) холболтын байгууламжийн ашиглалт үйлчилгээ, тоног төхөөрөмжүүдийн тасралтгүй найдвартай ажиллагааг ханган ажилладаг. “IGW станцыг Core Switch болгон өргөтгөх” төслийг хэрэгжүүлэх асуудлыг удирдан зохион байгуулж 2019 оны 6-р сард 2

удаагийн туршилт шалгалтыг вендор компанийн техникийн туслалцаагүйгээр гүйцэтгэж компанид 870 сая төгрөгийг хэмнэх томоохон ажлыг удирдан зохион байгуулсан. Ийм шилдэг инженерүүдийн нэг юм. Гурав дахь ажилтан бол Цагаанхүүгийн Дэлгэрмаа Радио холбооны инженер мэргэжилтэй, Өмнөговь аймгийн холбооны газрын Техник үйлчилгээний ахлах мэргэжилтэн. Монголын цахилгаан хобоо ХК-д 28 дахь жилдээ ажиллаж байна. Дэлгэрмаа бол Өмнөговь аймгийн холбооны газрын үйлчилгээг өргөтгөх, ашиглалт үйлчилгээний өдөр тутмын найдвартай ажиллагааг хариуцан ажилладаг шилдэг, сайн инженер. 2019 оны үйл ажиллагаагаараа 23 аймгийн салбараас нэгдүгээр байр эзэлсэн. Хамгийн сүүлийн амжилтыг нь танилцуулахад ийм байна.

Орон сууцны талаарх товч мэдээллийг хүргэе. Эхний орон сууц Улаанбаатар хот, Сонгино хайрхан дүүргийн 6-р хороо Хангийн материалын 58 Б байр, 54 тоот. 2 өрөө, 30 м.кв талбайтай, 1987 онд ашиглалтад орсон. 2007 оны 7 сарын 1-нд Монголын цахилгаан холбоо ХК-д шилжиж ирсэн. Анхны өртөг нь 21.5 сая төгрөг, хуримтлагдсан элэгдэл нь 4.03 сая төгрөг, үлдэх өртөг нь 17.47 сая төгрөг, энэхүү байрыг Төвийн бүсийн холбооны газрын инженер Ц.Нанжидад хувьчлан олгохоор санал оруулж байгаа. Нанжид нь тухайн байранд 12 дахь жилдээ амьдарч эзэмшиж байгаа. Хоёр дахь байр нь Улаанбаатар хот, Баянзүрх дүүргийн 3-р хороо, 12-р хороолол 4 А байр, 48 тоот. 2 өрөө байр, 30 м.кв талбайтай. 1985 онд ашиглалтад орсон. 2003 оны 8 сарын 1-нд Монголын цахилгаан холбоо ХК-д шилжиж ирсэн. Анхны өртөг нь 16.8 сая төгрөг, хуримтлагдсан элэгдэл нь 4.2 сая төгрөг, үлдэх өртөг нь 12.6 сая төгрөг. Технологийн газрын ахлах инженер М.Баярсайханд хувьчлан олгохоор. Гурав дахь байр нь Өмнөговь аймаг Даланзадгад сум, 3-р баг 23-р байрны 4 тоот. Өрөөний тоо 2, 63 м.кв талбайтай, 1994 онд ашиглалтад орсон. 1994 оны 2 сарын 21-ны өдөр Монголын цахилгаан холбоо ХК-ийн хөрөнгөд бүртгэгдсэн. Анхны өртөг нь 9.51 сая төгрөг, хуримтлагдсан элэгдэл нь 3.09 сая төгрөг, үлдэх өртөг нь 6.42 сая төгрөг (Өмнөговь АХГ-ын Техник үйлчилгээний ахлах мэргэжилтэн Ц.Дэлгэрмаад хувьчлан олгох). Ингээд гурван байрны нийт үлдэх өртөг нь 36.4 сая төгрөгийг төлүүлж хувьчлах саналыг та бүхэнд танилцуулж байна. Та бүхэн хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү гэж хүсч байна. Баярлалаа.

Ч.Пүрэвсүрэн, хурлын дарга: Хурлаар хэлэлцэх асуудлуудтай холбогдсон мэдээллийг хүргэж дууслаа. Хэлэлцэх асуудалтай холбоотой, хэлэлцэх асуудлын талаарх нэмж асуух, тодруулах зүйл байвал асуулт, хариулт, саналын хэсэгтээ орёе.

Асуулт хариулт, санал:

Ч.Пүрэвсүрэн, хурлын дарга: Өнөөдрийн хурал маань өндөржүүлсэн бэлэн байдлын нөхцөлөөс болоод 4 танхимд хуваагдан хуралдаж байгаа. Асуулт байвал өрөөнүүдээсээ дэлгэцээр гараа өргөвөл өрөөнүүдийн микрофоныг нээж өгье. Өрөө болгонд микрофон байрлуулсан байгаа.

408 тоот өрөөнд байгаа хувьцаа эзэмшигчдээс асуулт байна уу? ... За, байхгүй байна.

409 тоот хурлын өрөөнд асуулт байна уу? ... байхгүй байна.

410 тоот өрөөнд асуулт байна уу? 410 тоот өрөөнд дүрсээ өгнө үү? ... за асуулт байхгүй байна.

Үндсэн хурлын өрөөнд байгаа хувьцаа эзэмшигчдээс асуулт, санал байвал санал, асуултын микрофон дээр очиж болно эсвэл ширээн дээр байгаа микрофоныг ашиглаж болно.

Ч.Пүрэвсүрэн, хурлын дарга: Хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигчдээс санал, асуулт байхгүй байна гэж ойлголоо. Асуулт хариултын хэсгээ хаах уу?

Ч.Пүрэвсүрэн, хурлын дарга: Асуулт хариулт, саналын хэсгээ ингээд хаая. Хурлаар хэлэлцэх асуудлаар санал хураалт явуулах байгаа. Та бүхэн хурлын материалтай хамт

тараасан саналын хуудаснууд дээр саналаа бөглөж тооллогын комиссын санал хураалтын хайрцагт хийнэ үү. Тооллогын комиссоос санал хураалтын хайрцгийг өрөөнүүдээр явуулж саналаа авна.

Ч.Пүрэвсүрэн, хурлын дарга: Санал хураалтыг авч дууссан байна. Тооллогын комисс санал хураалтын тооллогын ажилд орно. Хурлын түр завсарлага зарлаж байна. Энэ хооронд та бүхэн ОТТ-ийн технологитой танилцаж болно. Оюунцэцэг дарга танилцуулна.

Б.Оюунцэцэг, Техник хөгжлийн албаны дарга: ОТТ технологийн талаар танилцуулав.

Ч.Пүрэвсүрэн, хурлын дарга: Хэлэлцэх асуудлаар өгсөн саналын тооллого хийж дууссан байна. Тооллогын комиссын тооллогын дүнг танилцуулна уу хэмээн тооллогын комиссын дарга Ганцэцэгийг индэрт урьж байна.

Д.Ганцэцэг, Тооллогын комиссын дарга: Санал хураалтын дүн, тооллогын комиссын тогтоолыг танилцуулав.

Ч.Пүрэвсүрэн, хурлын дарга: 2020 оны Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолыг уншиж танилцуулан хурлыг хаав.

Санал хураалтын дүнгийн тухай:

Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд 24,505,022 ширхэг хувьцаа эзэмшиж буй 18 хувьцаа эзэмшигч саналаа өгсөн байна. Үүнээс 18 саналын хуудас хүчинтэй, 0 саналын хуудас хүчингүй байна.

Саналын хуудсанд 6 асуудал шийдвэрлүүлэхээр оруулсан бөгөөд асуудал тус бүрээр доорх санал өгсөн байна. Үүнд:

1. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай 1-р асуудалд
Зөвшөөрсөн 18 санал буюу 100 хувь 24,505,022 ширхэг хувьцаа
Татгалзсан 0 санал буюу 0 хувь 0 ширхэг хувьцаа
2. Компанийн 2019 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах тухай 2-р асуудалд
Зөвшөөрсөн 18 санал буюу 100 хувь 24,505,022 ширхэг хувьцаа
Татгалзсан 0 санал буюу 0 хувь 0 ширхэг хувьцаа
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлтийг батлах тухай 3-р асуудалд
Зөвшөөрсөн 18 санал буюу 100 хувь 24,505,022 ширхэг хувьцаа
Татгалзсан 0 санал буюу 0 хувь 0 ширхэг хувьцаа
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлж, сонгох тухай 4-р асуудалд Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдэд кумулятив аргаар санал өгснөөс

Ц.Баяр-Эрдэнэ	4,958 хувьцааны санал 0.0101 хувь
Д.Ариунтуяа	349 хувьцааны санал 0.0007 хувь
Ц.Шинэхүү	24,504,316 хувьцааны санал 49.9986 хувь
М.Лхагважав	24,500,421 хувьцааны санал 49.9906 хувь
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны зардлын төсвийг батлах тухай 5-р асуудалд
Зөвшөөрсөн 18 санал буюу 100 хувь 24,505,022 ширхэг хувьцаа
Татгалзсан 0 санал буюу 0 хувь 0 ширхэг хувьцаа

6. Орон сууц хувьчлах тухай 6-р асуудалд
Зөвшөөрсөн 18 санал буюу 100 хувь 24,505,022 ширхэг хувьцаа
Татгалзсан 0 санал буюу 0 хувь 0 ширхэг хувьцаа

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

1. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийсэн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай асуудлыг 100 хувийн саналаар батлав.
 - a. Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг зөвшөөрч батлав.
2. Компанийн 2019 оны санхүүгийн тайлан, түүнд хийсэн хараат бус аудитын тайлан дүгнэлтийг батлах тухай асуудлыг 100 хувийн саналаар батлав.
 - a. Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан тэнцлийг дор дурдсанаар батлав:
 - Нийт хөрөнгийг 42,083,617,883 (дөчин хоёр тэрбум наян гурван сая зургаан зуун арван долоон мянга найман зуун наян гурав) төгрөгөөр, үүнээс эргэлтийн бус хөрөнгийг 30,289,710,825 (гучин тэрбум хоёр зуун наян есөн сая долоон зуун арван мянга найман зуун хорин тав) төгрөгөөр;
 - Өр төлбөрийн нийт дүнг 7,485,506,944.58 (долоон тэрбум дөрвөн зуун наян таван сая таван зуун зургаан мянга есөн зуун дөчин дөрөв) төгрөгөөр;
 - Эзэмшигчийн өмчийг 34,598,110,938.99 (гучин дөрвөн тэрбум таван зуун ерэн найман сая нэг зуун арван мянга есөн зуун гучин найм) төгрөгөөр тус тус батлав.
 - b. Монголын цахилгаан холбоо ХК-ийн хараат бус аудитын байгууллагаар хийлгэсэн аудитын тайлан, дүгнэлтийг зөвшөөрөв.
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлтийг батлах тухай асуудлыг 100 хувийн саналаар батлав.
 - a. Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн ТУЗ-ийн Аудитын хорооны дүгнэлтийг зөвшөөрч батлав.
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлж, сонгох тухай асуудалд кумулятив аргаар хамгийн өндөр санал авсан Ц.Шинэхүү М.Лхагважав нарыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгов.
 - a. Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд нэр дэвшигчдээс кумулятив аргаар хамгийн олон санал авсан Цэрэннадмидын Шинэхүү, Мандалын Лхагважав нарыг 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдрөөс Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр тус тус сонгосугай.
 - b. Цэнддаваагийн Баяр-Эрдэнэ, Доржгочоогийн Ариунтуяа нарыг Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүний үүрэгт ажлаас 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдрөөр тасалбар болгон тус тус чөлөөлж, бүрэн эрхийг нь дуусгавар болгосугай.
 - c. Компанийн үйл ажиллагааг үр ашигтай удирдан зохион байгуулж, холбогдох хууль, дүрэм, журмын дагуу ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны зардлын төсвийг батлах тухай асуудлыг 100 хувийн саналаар батлав.
 - a. Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны зардлын төсвийг хавсралтаар батлав.


- b. Батлагдсан төсвийн зарцуулалтад хяналт тавьж, зардал хэтрүүлэхгүй, гишүүдийн цалинг тэдний ажлын үр дүнг харгалзан олгож байхыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад үүрэг болгов.
6. Орон сууц хувьчлах тухай асуудлыг 100 хувийн саналаар батлав.
- a. Монголын цахилгаан холбоо ХК-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Y-2201006788 тоот улсын бүртгэлийн дугаартай, Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 6 дугаар хороо, Ханын материалын 58/Б дугаар байрны 54 тоот хаягт байрлах 30 квадрат метр талбай бүхий орон сууцыг Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төвийн бүсийн холбооны газрын кроссын инженер Цогзолын Нанжидад, 2204009184 тоот улсын бүртгэлийн дугаартай, Нийслэлийн Баянзүрх дүүргийн 3 дугаар хороо, 12 дугаар хороолол 4А байрны 48 тоот хаягт байрлах 30 квадрат метр талбай бүхий орон сууцыг Технологийн газрын Техникийн ашиглалт, үйлчилгээний албаны ахлах инженер Мягмарын Баярсайханд, 3401194001 хөрөнгийн дугаартай, Өмнөговь аймгийн Даланзадгад сумын 3 дугаар баг, 23 дугаар байрны 4 тоот хаягт байрлах 63 квадрат метр талбай бүхий орон сууцыг Өмнөговь аймгийн холбооны газрын Техник үйлчилгээний ахлах мэргэжилтэн Цагаанхүүгийн Дэлгэрмаад тус тус үлдэгдэл өртгөөр нь хувьчлан олгов.
- b. Орон сууцны үлдэгдэл өртөг болох 17,469,139.91 төгрөг төлөхийг Цогзолын Нанжид, 12,603,239.32 төгрөг төлөхийг Мягмарын Баярсайхан, 6,417,227.48 төгрөг төлөхийг Цагаанхүүгийн Дэлгэрмаа нарт тус тус даалгав.
- c. Орон сууц хувьчлах, үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийн гэрчилгээг шилжүүлэх, компанийн үндсэн хөрөнгөөс хасах ажлыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж ажиллахыг Гүйцэтгэх захирал /М.Алтан-Очир/-д даалгав.

ТАНИЛЦСАН:



Ч.ПҮРЭВСҮРЭН, 2020 ОНЫ ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ДАРГА

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:



Х.ЦЭЦЭГМАА, ТУЗ-ИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

2020 оны 4 дүгээр сарын 30
Улаанбаатар хот.